

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монголын төмөр зам ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/055/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас:
[www.audit.mn](#)
Улаанбаатар хот
2025 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](#)
Аудитын менежер: Д.Энхдалай
Утас: 260512 Цахим хаяг: [enkhdalaid@audit.gov.mn](#)
Аудитор: Ц.Энхжаргал
Утас 261628 Цахим хаяг: [enkhjargalts@audit.gov.mn](#)
Мишээл-Од Аудит ХХК-ийн захирал: Т.Одончимэг
Утас: 70169029 Цахим хаяг: [info@misheelodaudit.mn](#)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ О.БАТЧУЛУУН
ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.21 № 07/1121
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын төмөр зам ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн эд хөрөнгийн тооллогоор 443.6 сая төгрөгийн бараа материал дутагдсан, 2019-2022 онд хэрэгжсэн төмөр замын бүтээн байгуулалтын төсөлд ашиглагдаж байсан 770.5 сая төгрөгийн хөрөнгө бодитоор байхгүй, худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртгийн хязгаарыг баримтлаагүй 221.1 сая төгрөгийн шууд гэрээ байгуулсан, шууд худалдан авалт хийсэн, бараа материалын үлдэгдлийг тооцохгүйгээр 63 нэр төрлийн 479.2 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч нэмж нөөц үүсгэсэн, анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж бүртгэлд тусгасан зэрэг 2,011.7 сая төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 19 дүгээр зүйлийн 19.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 1.4, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.1.6, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10.2 дахь заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын "нийцсэн ба зохистой байх", "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Монголын төмөр зам ТӨХК нь хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу өөрийн эзэмшлийн 7 зүтгүүрийг 26,563.9 сая төгрөгөөр их засварт оруулж, ашиглалтад хүлээн авснаар ачаа тээврийн үйл ажиллагаа өмнөх оноос 163.0 хувиар нэмэгдэж, орлогын төлөвлөгөөг 8,442.1 сая төгрөгөөр давуулан биелүүлж, зардлыг 17,877.3 сая төгрөгөөр хэмнэж, татвар төлөхийн өмнөх ашиг 35,312.9 сая төгрөг буюу 354.9 хувийн биелэлттэй ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Үндэсний төмөр замын сүлжээг 2023 онд 416.1 километрээр өргөтгөж, 08 дугаар сард Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг улсын комисс байнгын ашиглалтад хүлээж авсан байна. Тус төмөр зам нь 1 өртөө 6 зөрлөгтэй жилд 15 сая.тн ачаа тээвэрлэх хүчин чадалтай, 1,385,599.8 сая төгрөгийн өртөг бүхий төмөр замын хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэх зохион байгуулалтын ажил хийгдэж байна.

Бусад асуудлын хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 65 дугаар тогтоолоор Монголын төмөр зам ТӨХК-ийн эзэмшиж байсан Тавантолгой төмөр зам ХХК-ийн 34 хувийн хувьцааг Монголын төмөр зам ТӨХК-ийн гаргасан 750,000.0 сая төгрөгийн бондоос суутган тооцох замаар Эрдэнэс Тавантолгой ХК-д шилжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан /төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	41,320,277,023.12	59,535,646,696.37
1.1.2	Дансны авлага	31,753,857,995.64	25,450,546,085.01
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	36,683,827,715.54	15,361,895,432.76
1.1.4	Бусад авлага	67,973,823,538.08	68,644,836,937.35
1.1.6	Бараа материал	9,463,033,715.47	14,344,060,064.82
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	29,051,364,443.62	37,638,075,022.24
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	2,611,870,635.56	2,611,870,635.56
	Эргэлтийн хөрөнгийн дүн	218,858,055,067.03	223,586,930,874.11
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	238,604,915,229.31	232,371,994,081.84
1.2.2	Биет бус хөрөнгө	13,487,982,577.45	13,442,376,432.89
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	693,765,710,701.48	693,765,710,701.48
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	6,132,487,137.24	6,043,448,439.76
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	11,706,564.64	11,706,564.64
1.2.9	Дуусаагүй барилга	1,291,500,239,582.06	1,385,599,831,047.05
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,243,503,041,792.18	2,331,235,067,267.66
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,462,361,096,859.21	2,554,821,998,141.77
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	23,689,493,967.14	5,599,641,586.52
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	48,943,292,597.10	21,853,826,351.80
2.1.1.4	НДШ-ийн өглөг	8,998.95	27,679,561.34
2.1.1.6	Хүүний өглөг	5,432,339,209.65	8,863,385,691.15
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	6,200,229,210.14	3,622,153,863.24
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	51,294,628,619.10	15,424,566,803.88
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	135,559,992,602.08	55,391,253,857.93
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	333,753,143,895.09	334,682,989,366.50
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	1,753,978,930.39	3,044,910,142.72
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	1,336,123,253,693.00	1,475,504,630,885.05
2.1.2.5		-	-
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,671,630,376,518.48	1,813,232,530,394.27
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,807,190,369,120.56	1,868,623,784,252.20
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	20,727,658,514.60	20,727,658,514.60
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	139,351,735.55	766,546,968.88
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	768,206,030,794.14	768,206,030,794.14
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(133,902,313,305.64)	(103,502,022,388.05)
2.3.11	Эздийн өмчийн дүн	655,170,727,738.65	686,198,213,889.57
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,462,361,096,859.21	2,554,821,998,141.77

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	67,849,134,181.34	122,511,279,362.08
2	Борлуулалтын өртөг	40,028,707,162.68	79,640,696,874.04
3	Нийт ашиг(алдагдал)	27,820,427,018.66	42,870,582,488.04
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүгийн орлого	771,919,583.83	4,646,131,062.82
8	Бусад орлого	51,054,518.70	7,824,590,486.89
10	Ерөнхий ба удирдлагын зардал	11,004,021,009.77	8,987,079,525.63
11	Санхүүгийн зардал	5,772,899,484.94	4,510,164,909.87
12	Бусад зардал	869,727,242.76	5,700,241,204.92
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	3,376,072,087.50	(958,180,097.97)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(29,798,996.26)	127,322,569.85
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	14,343,026,474.96	35,312,960,869.21
19	Орлогын татварын зардал	1,438,685,497.11	5,083,431,925.75
20	Татварын дараах ашиг (алдагдал)	12,904,340,977.85	30,229,528,943.46
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	12,904,340,977.85	30,229,528,943.46
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
24	Орлогын нийт дүн	12,904,340,977.85	30,229,528,943.46
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	20,727,658,514.60	139,351,735.55	768,206,030,794.14	(98,241,019,835.32)	620,832,021,208.97
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(48,565,634,448.17)	(48,565,634,448.17)
Залруулсан үлдэгдэл	20,727,658,514.60	139,351,735.55	768,206,030,794.14	(146,806,654,283.49)	642,266,386,760.80
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	12,904,340,977.85	12,904,340,977.85
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	20,727,658,514.60	139,351,735.55	768,206,030,794.14	(133,902,313,305.64)	655,170,727,738.65
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	815,979,024.13	815,979,024.13
Залруулсан үлдэгдэл	20,727,658,514.60	139,351,735.55	768,206,030,794.14	(133,086,334,281.51)	655,986,706,762.78
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	30,229,528,943.46	30,229,528,943.46
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	(645,217,050.00)	645,217,050.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	627,195,233.33	-	-	627,195,233.33
2024 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	20,727,658,514.60	766,546,968.88	768,206,030,794.14	(103,502,022,388.05)	686,198,213,889.57

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	60,004,373,075.41	121,150,928,153.53
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	56,341,955,953.85	120,646,235,776.19
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	28,982,388.00	38,632,238.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	8,422,144.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	3,633,434,733.56	457,637,995.34
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	47,263,994,192.95	86,749,637,203.82
1.2.1	Ажиллагчдад төлсөн	17,822,573,505.89	20,482,629,941.91
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	5,065,270,483.52	5,964,831,893.80
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	11,331,966,227.50	13,347,549,632.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	2,077,531,289.58	9,091,877,712.67
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,640,285,640.86	14,470,177,837.76
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	218,152,345.55	499,999,298.37
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	2,404,809,267.41	18,091,431,874.07
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	35,409,590.61	56,083,094.79
1.2.9	Бусад мөнгөн зарлага	3,667,995,842.03	4,745,055,918.45
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	12,740,378,882.46	34,401,290,949.71
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	3,809,406,140.63
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	-	3,809,406,140.63
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	32,030,257,217.62	60,908,470,049.35
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	31,990,707,817.62	56,290,872,689.35
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	39,549,400.00	5,500,000.00
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	4,612,097,360.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(32,030,257,217.62)	(57,099,063,908.72)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	52,430,005,809.00	41,558,349,032.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	52,430,005,809.00	41,558,349,032.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	13,240,831.11	645,217,050.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	13,240,831.11	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	645,217,050.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	52,416,764,977.89	40,913,131,982.00
4	Валютын ханшийн зөрүү	25,137.45	10,650.26
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	33,126,911,780.18	18,215,369,673.25
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,193,365,242.94	41,320,277,023.12
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	41,320,277,023.12	59,535,646,696.37

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	2023 оны гүйцэтгэл	2024 он		/сая төгрөгөөр/ Өсөлт, бууралт (+)	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ОРЛОГО	71,558,191.6	126,539,827.2	134,982,000.9	8,442,173.7	106.7
2.1	Хөдлөх бүрэлдэхүүн, бусад түрээс	3,103,158.8	5,460,141.6	4,774,311.5	(685,830.5)	87.4
2.2	Төмөртэй тээвэр	1,704,200.0	1,862,190.4	3,784,984.2	1,922,793.8	203.3
2.3	Зам анги	324,810.8	3,139,860.7	2,905,400.4	(234,460.6)	92.5
2.4	Цогтцэций тээвэр	58,624,320.0	112,287,312.5	107,254,261.5	(5,033,051.5)	95.5
2.5	/ШАЦ,Замын-үүд/	4,092,645.0	3,790,322.0	3,790,322.0	-	100.0
2.6	Бусад орлого	3,709,057.0	-	12,470,721.5	12,470,721.5	-
3	НИЙТ ЗАРДАЛ	57,675,355.0	116,715,518.2	98,838,182.2	(17,877,336.0)	84.7
3.1	Үүнээс: Ерөнхий удирдлагын зардал	11,020,024.0	27,175,518.6	8,987,079.5	(18,188,439.1)	33.1
4	Ханшийн зөрүүний ашиг /алдагдал/	3,376,072.1	-	(958,180.1)	(958,180.1)	-
4.1	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/	-	-	127,322.6	127,322.6	-
5	Татварын өмнөх ашиг /алдагдал/	14,343,027.0	9,824,309.0	35,312,960.9	25,488,652.2	359.4
6	Орлогын албан татвар	1,438,686.0	982,430.9	5,083,431.9	4,101,001.0	517.4
7	Цэвэр ашиг (алдагдал)	12,904,341.0	8,841,878.1	30,229,528.9	21,387,651.2	341.9
8	Төсвийн төлбөрт нийт дүн	6,389,387.9	18,925,210.0	23,754,141.2	4,828,931.2	125.5
8.1	а/ Орлогын албан татвар	1,438,686.0	2,836,478.9	5,083,431.9	2,246,953.0	179.2
8.2	б/ НӨТ	-	4,732,218.2	6,136,799.0	1,404,580.8	129.7
8.3	в/ НДШ	2,600,255.0	3,177,075.1	3,296,141.7	119,066.6	103.7
8.4	г/ Хүн амын орлогын албан татвар	1,989,043.0	2,240,209.0	2,300,040.3	59,831.3	102.7
8.5	д/Үл хөдлөх хөрөнгийн татвар	152,602.0	2,221,135.4	2,663,974.8	442,839.4	119.9
8.6	е/Гаалийн татвар	44,807.0	3,712,062.4	3,599,611.0	(112,451.4)	97.0
8.7	ё/Тээврийн хэрэгслийн татвар	3,202.9	6,031.0	4,840.8	(1,190.2)	80.3
8.9	ж/Бусад татвар	160,792.0	-	669,301.7	669,301.7	-
9	Төрийн өмчийн ногдол ашиг	207,277.0	207,277.0	645,217.1	437,940.1	311.3
10	Нийт ажиллагсдын тоо	550.0	599.0	599.0	-	100.0
11	Нийт цалингийн сан	21,043,225.0	28,432,196.2	27,975,575.9	(456,620.3)	98.4
12	Нэг ажилтны дундаж цалин	3,188.4	3,955.5	3,892.0	(63.5)	98.4
13	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох	0.8	0.9	0.7	(0.2)	79.3

Монголын төмөр зам ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

	зардал					
14	Хөрөнгө оруулалт	718,969.0	62,426,260.6	23,966,549.7	(38,459,710.9)	38.4
15	Нийт авлага	99,727,600.0	20,956,150.4	109,457,278.5	88,501,128.1	522.3
16	Нийт өглөг	1,756,754,458.1	1,674,558,201.0	1,868,623,784.3	194,065,583.2	111.6
16.1	Богино хугацаат өр төлбөр	135,559,993.0	18,219,414.5	55,391,253.9	37,171,839.4	304.0
16.2	Урт хугацаат өр төлбөр	1,671,630,377.0	1,656,338,786.6	1,813,232,530.4	156,893,743.8	109.5

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Аудитаар нийт 1,169.6 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 4 алдаа илэрснээс аудитын явцад 1,124.7 сая төгрөгийн 3 алдааг санхүүгийн тайланд залруулсан, залруулагдаагүй 44.9 сая төгрөгийн 1 алдаанд зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Тоног төхөөрөмжийн ангилалд хамаарах 13 харилцагчтай холбоотой 943.9 сая төгрөгийн ажил гүйлгээний НӨАТ-ыг хувь тэнцүүлэн хасагдах НӨАТ-аар бүртгээгүй	1	943.9	-	-	1	943.9	1	943.9	-	-	-	-
2	Үйл ажиллагааны орлогыг 171.9 сая төгрөгөөр дутуу тайлагнасан	1	171.9	1	171.9	-	-	1	171.9	-	-	-	-
3	Санхүүгийн тайланд НДШ-ийн өглөгийг 8.9 сая төгрөгөөр илүү тайлагнасан	1	8.9	-	-	1	8.9	1	8.9	-	-	-	-
4	Бараа материалын дансанд тоо хэмжээ 0 утгатай, үлдэгдэл өртөгтэй хөрөнгө болон 1 төгрөгөөр бүртгэсэн 105 нэр төрлийн 44.9 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.	1	44.9	-	-	1	44.9	-	-	1	44.9	1	44.9
	Дүн	4	1,169.60	1	171.9	3	997.7	6	1,124.70	1	44.9	1	44.9

Аудитаар нийт 1,966.8 сая төгрөгийн 8 зөрчил илэрснээс 4.0 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1,914.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах, таслан зогсоох 4 албан шаардлага хүргүүлж, 48.3 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ажилтнуудын ажилласан жилийн бүртгэл, судалгаа хангалтгүйгээс 6 ажилтанд ажилласан жилийн нэмэгдэл 4.0 сая төгрөгийг илүү олгосон байна.	1	4.0	1	4.0	-	-	-	-
2	Өмнөх аудитаар эд хөрөнгийн тооллогоор дутагдсан 443.6 сая төгрөгийн бараа материал, 2019-2022 онд хэрэгжсэн төмөр замын бүтээн байгуулалтын төсөлд ашиглагдаж байсан 770.5 сая төгрөгийн хөрөнгө нийт 1,214.2 сая төгрөгийн хөрөнгө бодитоор байхгүй, дутагдал илэрснийг хуулийн байгууллагад шилжүүлэх албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байна.	1	1,214.2	-	-	1	1,214.2	-	-
3	Тайлант онд худалдаж аваад, зарцуулаагүй 63 нэр төрлийн 479.2 сая төгрөгийн бараа материалын нөөц нэмж үүсгэсэн, өмнөх аудитаар бараа материалын үлдэгдлийг тооцохгүйгээр тайлант оны хэрэгцээг үндэслэн төлөвлөдөг, чанарын шаардлага хангахгүй, бараа материал худалдан авсан, насжилт өндөртэй бараа материалын нөөц үүсгэсэн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	1	479.2	-	-	1	479.2	-	-
4	Шатахуун нийлүүлэх, МТЗ/20240102155 кодтой тендерийн багц-1-т 5.1 сая төгрөг, багц-2-т 11.3 сая төгрөгийн үнийн хөнгөлөлт үзүүлэх саналыг тендерт шалгарсан Сод Монгол групп ХХК-аас ирүүлсэн ба гэрээ байгуулахдаа үнийн хөнгөлөлтийг тооцоогүй, тендерт ирүүлсэн үнийн санал 547.2 сая төгрөгөөр гэрээ байгуулсан. Харьцуулалтын аргаар худалдан авах 52.9 сая төгрөгийн барааг нэр төрлөөр нь задалж шууд худалдан авалт хийсэн байна.	1	69.3	-	-	1	69.3	-	-
5	"Дүрэмт хувцас худалдан авах" 214.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тендерт оролцогчдыг шалгаруулахдаа ижил төстэй бараа нийлүүлсэн туршлага хангаагүй Урбан жийнс ХХК-ийг сонгон шалгаруулсан нь гэрээний үүргээ биелүүлж чадахгүйд хүрч, Бөртэ ТӨҮГ-тай 151.8 сая төгрөгийн шууд гэрээ байгуулсан.	1	151.8	-	-	1	151.8	-	-
6	УИХ, ЗГ-ын бодлого шийдвэрийг сурталчлах, таниулах, мэдээлэл өгөх зорилгоор зарцуулсан 28.0 сая төгрөгийн томилолтын зардал нь анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.	1	28.0	-	-	-	-	1	28
7	Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг 240 хүнд 10.2 сая төгрөгийн илүү, 10 хүнд 1.9 сая төгрөгийн дутуу хөнгөлөлт эдлүүлж, өглөг авлагад тусгаагүй байна.	1	12.1	-	-	-	-	1	12.1
8	Гэрээт ажлын хөлс 35.8 сая төгрөгийг 8 иргэнд олгохдоо нийгмийн даатгалын шимтгэл	1	8.2	-	-	-	-	1	8.2

Монголын төмөр зам ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

	8.2 сая төгрөгийг суутгаагүй, тайлагнаагүй байна.								
	Дүн	8	1,966.8	1	4.0	4	1,914.5	3	48.3

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 2 зөрчилд зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөг/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
1	Үнэлгээний хорооны ажилтнууд тендерийг үнэлэхдээ Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/255 дугаар тушаалын хавсралт “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ын дагуу холбогдох маягтуудыг хөтлөөгүй, ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдлийг дутуу бөглөсөн зэрэг нийтлэг зөрчлүүд байна.	1	-	-	-	1	-
2	Оны эхэнд батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2 удаа тодотгож 33,151.5 сая төгрөг буюу 55.6 хувиар нэмэгдүүлсэн мөн үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан шинэ техник технологийг нэвтрүүлэх, төмөр замын машин механизмыг засварлах, хил дамнуулан зөөж тээвэрлэх зэрэг ажлууд урт хугацаанд, он дамжин хэрэгжиж байгааг дараа оны бизнес төлөвлөгөөнд тусгаагүй зэрэг зөрчил байна.	1	-	-	-	1	-
	Дүн	1	-	-	-	1	-